



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ

2024 оны 04 сарын 02 өдөр

Дугаар 13

Мандалговь

Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл  
олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.1, 77.3 дахь заалт, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2023 оны 798 дугаар тогтоол, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 09 дүгээр тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ийн 1 дүгээр зүйлийн 1.3 дахь заалт, 4 дүгээр зүйлийн 4.3 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Дэлгэрцогт суманд барьж, ашиглалтад оруулсан нийт 2,447,379,693 (хоёр тэрбум дөрвөн зуун дөчин долоон сая гурван зуун далан есөн мянга зургаан зуун ерэн гурав) төгрөгийн өртөгтэй 150 ортой цэцэрлэгийн барилгыг Дэлгэрцогт сумын Хүүхдийн цэцэрлэгийн үндсэн хөрөнгөд хавсралтын дагуу бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Дэлгэрцогт сумын Хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгч (Х.Эрдэнэтуяа)-д дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай.

2.1 Байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналт дор үндсэн хөрөнгө бүртгэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2 Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3 Энэ тогтоолын биелэлтийг 2024 оны 5 дугаар сард багтаан Орон нутгийн өмчийн газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (Ц.Мөнхбат)-д үүрэг болгосугай.

ДАРГА



С.ОД-ЭРДЭНЭ

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
2024 оны 04 дүгээр сарын 22-ний өдрийн  
13 тогтоолын хавсралт

Дэлгэрцогт сумын Хүүхдийн цэцэрлэгийн үндсэн хөрөнгөд  
бүртгэх хөрөнгийн мэдээлэл

№	Хөрөнгийн нэр	Биет хэмжээ	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Цэцэрлэгийн барилга	м.кв	957		2,100,882,763
2	Гадна дулаан	м	373	263,220	98,181,060
3	Гадна цэвэр ус	м	32	56,051	1,793,632
4	Гадна бохир ус	м	23	144,620	3,326,260
5	Гадна холбоо	м	250	39,990	9,997,500
6	<b>Гадна цахилгаан</b>				
	- дэд өртөө	ком	1	8,265,397	78,537,007
	- Цахилгааны шугам	м	2010	34,960.47	
7	<b>Гадна тохижилт</b>				
	Явган зам	м.кв	930	95,134	88,474,620
	Машины зогсоол	м3	121	98,173	11,878,933
	Гадна гэрэлтүүлэг	ком	15	2,661,782	39,926,730
	Зөөврийн хогийн сав	ш	2	103,651	207,302
	Хогийн сав	ш	8	373,327	2,986,616
	Сандал	ш	16	338,365	5,413,840
	Сүүдрэвч	ш	2	631,715	1,263,430
	Зүлэг	м2	173	5,000	865,000
	Улиас, шар хуайс, хайлаас мод	ш	243	15,000	3,645,000
<b>Нийт төсөвт өртөг</b>					<b>2,447,379,693</b> (хоёр тэрбум дөрвөн зуун дөчин долоон сая гурван зуун ерэн долоон мянга зургаан зуун ерэн гурав) төгрөг